



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2017 оны 11 сарын 02 өдөр

Дугаар А/199

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/146 дугаар тушаалаар батлагдсан Нийцлийн аудитын түр журмын 9.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Нийслэлийн Авто замын хөгжлийн газарт хэрэгжсэн зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт"-д хийсэн эрсдэлийн аудитын тайлан /УАГ-НАГ/2017/10-НА-ЭА/-г хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Нийслэлийн Авто замын хөгжлийн газар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын тайланд дурьдагдсан зөрчлүүдийг арилган, өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2017 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч /С.Батболд/, Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын дарга /Ж.Тогтохбаяр/, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дарга /Э.Болормаа/ нарт тус тус зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, зөрчилтэй асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхийг Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд Тэргүүлэх аудитор /Б.Алтанзул/-т даалгасугай.

5. Аудитын хүрээнд цугласан нотлох баримт, бусад баримт бичгийг зохих журмын дагуу архивын нэгж болгон архивт хүлээлгэн өгөхийг Аудитын багт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ХҮРЭЛБААТАР

## АГУУЛГА

<b>Тайланг бэлтгэсэн:</b>	Товчилсон үгийн жагсаалт .....	3
<b>YAГ-ын Нийцлийн аудитын газар</b>	Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй .....	4
Газрын захирал	Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт .....	4
Б.Алтанзул	Үндсэн мэдээлэл .....	5
<b>Нийслэл дэх Төрийн аудитын газар</b>	<b>НЭГ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТЛАХДАА БАТАЛГААЖСАН ЗУРАГ, ТӨСВИЙГ ҮНДЭСЛЭСЭН ЭСЭХ</b>	
Шинжээч	1.1 Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг батлахдаа баталгаажсан зураг, төсвийг үндэслэсэн эсэх.....	6
Б.Номинбаатар	1.2 НАЗГ нь төсөвт тусгагдаагүй, зураг төсөвгүй 1 ажлыг гэрээ байгуулахгүйгээр гүйцэтгүүлсэн зөрчил илэрлээ.....	7
Аудитор	<b>ХОЁР. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ХУУЛЬ ЖУРМЫН ДАГУУ ЯВУУЛСАН ЭСЭХ</b>	
Ж.Мөнхтуяа	2.1 Сонгон шалгаруулалтыг хууль журмын дагуу явуулсан эсэх.....	8
2017 оны 5 дугаар сар	2.2 ТБОНӨХБАҮХАТХ-ийн 28 дугаар зүйлийн 28.11 -д зааснаар «хамгийн сайн» гэж үнэлэгдэж, шалгарсан оролцогчийн тендерийн баримт материалыг шалгахад 4 үнэлгээний хорооны үйл ажиллагаанд дараах зөрчлүүд илэрлээ.....	8-9
Уг тайланг YAГ-ын Вэб сайтаас үзнэ үү. <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	<b>ГУРАВ. ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ҮЕ ШАТ БҮРТ ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ БОЛОН ДОТООД ХЯНАЛТЫГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ЯВУУЛСАН ЭСЭХ</b>	10
Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729, 260949 дугаарын утас, факсаар харилцана уу.	<b>ДӨРӨВ. САНХҮҮЖИЛТИЙГ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ОЛГОСОН ЭСЭХ</b>	12
	<b>ТАВ. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН АЖЛЫГ ДАНС БҮРТГЭЛД ТУСГАСАН ЭСЭХ</b>	13
	Дүгнэлт .....	14
	Зөвлөмж .....	15
	Холбогдох байгууллагын санал.....	16

### Хаяг:

Үндэсний Аудитын газар  
Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу-3  
Засгийн газрын  
IY байр  
Улаанбаатар хот 15160  
Монгол Улс

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

<b>АДБОУС</b>	Аудитын Дээд байгууллагын олон улсын стандарт
<b>ТБОНӨХБАУХАТХ</b>	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
<b>ЗГ</b>	Засгийн Газар
<b>ҮАГ</b>	Үндэсний Аудитын газар
<b>НАЗХГ</b>	Нийслэлийн Авто замын хөгжлийн газар
<b>НИТХ</b>	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
<b>НАЗГ</b>	Нийслэлийн Авто замын газар
<b>НЗД</b>	Нийслэлийн Засаг дарга
<b>НЗДТГ</b>	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
<b>НХААГ</b>	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар
<b>ШТС</b>	Шатахуун түгээгүүрийн станц

## ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

<b>Хүснэгт №1</b>	Төсөл арга хэмжээний нэр, зураг төсөв, түүнийг зохиосон байгууллагын судалгаа
<b>Хүснэгт №2</b>	Худалдан авах ажиллагаа явуулсан төслийн нэр, ажиллагааны арга
<b>Хүснэгт №3</b>	Магадлал хийлгээгүй, гэрээ хяналтын төсвөөс гүйцэтгэл илүү гарсан зөрчил
<b>Хүснэгт №4</b>	Шинжилгээний дүнгийн мэдээлэл
<b>Хүснэгт №5</b>	Ажил бүрэн дууссан боловч олгогдоогүй үлдэгдэл санхүүжилт
<b>Хүснэгт №6</b>	Нийт хэрэгжсэн авто зам, замын байгууламжийн ажлыг өмчийн бүртгэлд тусгасан байдлын судалгаа

## Аудит хийх үндэслэл

НИТХ-ын даргын 2017 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 01/145 дугаар албан бичгийг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8-д тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

### 1. Аудитын нэр:

Нийслэлийн Авто замын хөгжлийн газарт хэрэгжсэн зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт

### 2. Аудитын код:

ҮАГ-НАГ/2017/10-ЭА

### 3. Аудитын зорилт:

НАЗХГ-т хэрэгжсэн зарим хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аудит хийж дүгнэлт гаргаж, санал, зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэхэд аудитын зорилт оршино.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг батлахдаа баталгаажсан зураг, төсвийг үндэслэсэн эсэх;
- Сонгон шалгаруулалтыг хууль журмын дагуу явуулсан эсэх;
- Төсөл, арга хэмжээний үе шат бүрт захиалагчийн хяналт болон дотоод хяналтыг хууль, журмын дагуу явуулсан эсэх;
- Санхүүжилтийг хууль, журмын дагуу олгосон эсэх;
- Хөрөнгө оруулалтаар бий болсон ажлыг данс бүртгэлд тусгасан эсэх;

### 4. Хамрах хүрээ:

Аудитад НЗДТГ, Захирагчийн ажлын алба, НАЗХГ, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газруудыг хамруулан 2012-2016 онуудад нийслэлд хэрэгжсэн авто замын төсөл, хөтөлбөрүүдээс Нийслэл дэх Төрийн аудитын газраас жил бүрийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд хийсэн аудитад хамрагдсан байдал, ажлын төсөвт өртгийн хэмжээ, эрсдэлийн үнэлгээ зэргийг харгалзан түүвэрлэлт хийж, нийт 16 төсөл арга хэмжээний төлөвлөлт, сонгон шалгаруулалт, гүйцэтгэлийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу хэрэгжүүлсэн эсэхийг авч үзлээ.

### 5. Арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 300, 400, 4000, 4100, Төрийн хяналт шалгалтын стандартыг баримтлан холбогдох албан тушаалтанаас асуулга, лавлагаа, тайлбар, мэдээ гаргуулах, нотлох баримтыг баталгаажуулах, ажлын тайланг судлах зэрэг аудитын хөтөлбөр, горим, арга зүйн дагуу цуглуулсан нотлох зүйл, баримт материалд дүн шинжилгээ хийж зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг түүвэрчлэн шалгаж баталгаажуулав.

### 6. Аудит хийхэд ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитын зорилттой холбоотой дараахь хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг шалгуур болгон ашиглалаа. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 29.4 дүгээр зүйл;
- ТБОНӨХБАҮХАТХ- ийн 3.1, 14-16, 28.1 дүгээр зүйл;
- Авто замын тухай хуулийн 14.1, 14.2.4-5 дугаар зүйл;
- Барилгын тухай хуулийн 13.2, 15.2, 17.1, 25.4 дүгээр зүйл;
- Концессын тухай хуулийн 11 дүгээр зүйл;
- Барилга захиалагчийн дүрмийн 3.1.2, 3.1.7 дахь заалт;

- Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрмийн 7.1, 7.2 дахь заалт;
- Барилгын ажлыг эхлүүлэх үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрмийн 4.12.1, 4.12.3.1, 4.12.7 дахь заалт;
- НИТХ-ын 2012 оны 6/27, 2013 оны 13/51, 13/54, 2014 оны 21/31, 21/32, 22/34, 2015 оны 24/04, 31/24, 32/33, 2015 оны НИТХТ-ийн 147 дугаар тогтоол;
- НЗД-ын 2013 оны А/135, 2014 оны А/07-01, А/07-02, А/519-02, А/662-9, 2015 оны А/42, А/267, 2016 оны А/68, А/180, А/293 дугаар захирамжууд;

## **7. Аудит хийсэн багын бүрэлдэхүүн болон хугацаа:**

Аудитыг ҮАГ-ын Нийцлийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Б.Алтанзул хянан удирдаж, Нийцлийн аудитын газрын аудитор М.Туул, Нийслэл дэх Төрийн аудитын газрын шинжээч Б.Номинбаатар нар 2017 оны 4 дүгээр сарын 3-наас 2017 оны 4 дүгээр сарын 10-ны хооронд төлөвлөлтийг хийж, аудитын бүрэлдэхүүнд 2017 оны 4 дүгээр сарын 19-нөөс аудитор Ж.Мөнхтуяаг татан оролцуулж, 2017 оны 4 дүгээр сарын 11-ний өдрөөс 2017 оны 5 дугаар сарын 5-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэлийн болон тайлагналын үе шатыг хийж гүйцэтгэлээ.

## **8. Үндсэн мэдээлэл:**

НАЗХГ-аас 2012-2016 онд Улаанбаатар хотын авто замын сүлжээг сайжруулах чиглэлээр улс, нийслэлийн төсөв, “Шинэ бүтээн байгуулалт” хөтөлбөр, Азийн хөгжлийн банк, концессийн гэрээ, гадаадын зээл тусламж, Нийслэлийн замын сангийн хөрөнгөөр шинээр 116.66 км авто зам тавьж, 236.80 км авто замыг өргөтгөн шинэчилж, 1466,8 урт/метр гүүрийг шинээр барьж, 562,36 урт/метр гүүрийг өргөтгөн шинэчилж засварласан байна.

**НЭГ. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг батлахдаа баталгаажсан зураг, төсвийг үндэслэсэн эсэх**

1.1. Аудитаар тодорхойлсон эрсдэлийн <sup>1</sup> хүрээнд 2012-2016 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1, концессын гэрээгээр 3, орон нутгийн төсвөөр 12, нийт 90 332.1 сая төгрөгийн дүнтэй 16 чиглэлийн авто замын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулав.

Улс, нийслэлийн төсөв, концессын эх үүсвэрээр хэрэгжих хөрөнгө оруулалтын ажлын жагсаалтыг НИТХ-ын 2012 оны 6/27, 2013 оны 13/51, 13/54, 2014 оны 21/31, 21/32, 22/34, 2015 оны 24/04, 31/24, 32/33, 2015 оны НИТХТ-ийн 147 дугаар тогтоолуудаар тус тус баталжээ.

Аудитад хамрагдсан ажлуудын төсөл арга хэмжээний нэр, зураг төсөв, түүнийг зохиосон болон ажлын гүйцэтгэгч байгууллагын судалгааг хүснэгт 1-ээр үзүүлбэл:

№	Батлагдсан төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Батлагдсан төсөвт өртөг /сая.төг/	Зураг хийсэн компанийн нэр	Зураг төсвийг хянасан байгууллагын	
				Нэр	Огноо
1	СХД, Гүнтийн давааны авто замыг үргэлжлүүлэн 7.36 км авто зам	10 484.8	"ХЗТ-Авто зам" ХХК	Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар	2011.12.14
2	Өвөр Гүнтийн 11 км авто зам	13 333.7	"Ти Ай Би" ХХК	Барилгын хөгжлийн төв	2013.06.28
3	Нисэхийн товчоо-Био комбинат Шувуун фабрикийн чиглэлийн 22,5 км авто замын ажил	30 489.7	"МРСРсgr" ХХК	Зам тээврийн хөгжлийн төв	2013.04.09
4	Төмөр замын урдуурх хэвтээ тэнхлэгийн гол гудамж замын зүүн хэсгийн үргэлжлэл 6,0 км авто зам /Дүнжингарав худалдааны төвийн замаас Улиастайн уулзвар хүрэх/-ын ажил	10 901.8	"Батглостер" ХХК	Газрын харилцаа, барилга, геодези, зураг зүйн газар	2011.07.25
5	Гандийн гудамжны авто зам.	2 315.3	НЗТХ	Нийслэлийн зураг төслийн хүрээлэн	2007.04.05
6	Гэндэнгийн гудамжны 0.6 км авто зам	1 585.0	"Танил санаа" ХХК	Зам тээврийн хөгжлийн төв	2015.08.11
7	Яармагаас Жаргалантын ам орох 3,4 км авто зам, 400 автомашины зогсоол"-ын барилгын ажил	1 761.9	"Мөнхийн тод зам" ХХК	Зам тээврийн хөгжлийн төв	2016.07.25
8	Замын хөдөлгөөний зөрчил илрүүлэх болон авто замын хяналтын телекамер суурилуулах	2 678.0	МХС ТӨХК-ийн техникийн нөхцлөөр		
9	БАГЦ 2: Богд уулын арын 17.1 км авто замын гэрэлтүүлэг /241 дүгээр тулгуураас Баянзүрхийн товчоо хүртэлх/	531.9	"Бодь-Эрчим" ХХК	Эрчим хүчний хөгжлийн төв	2016.3.16
10	ТЭЦ-3 баруун талын 0.33км авто зам	зураг, төсөвгүй	=	=	=
11	Нарны замыг 19 дүгээр хорооллын арын замтай холбох 1.5 км авто зам, замын байгууламжийн 58 у.м, Төмөр зам доогуурх Нарны замтай холбогдсон 22 м тунелын хамт барих	4 359.8	"Ар Си Эс Си" ХХК	Барилгын Хөгжлийн төв	2014.12.30
12	Баянзүрх дүүргийн 23 дугаар хороо, Баатархайрханаас Гахайн хороо орох зам засварын ажил	232.9	"Ай Ай Ти Си" ХХК	НАЗХГ	=
13	Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо, Яргайтын богины ам	1 672.2	"Ай Ай Ти Си" ХХК	Зам тээврийн хөгжлийн төв	2015.08.26
14	Налайх дүүрэг, Петровис ШТС-ын уулзвараас Цайз зах хүртэлх 1.3 км автозамын ажил	1 035.7	"ТЗТТ"ХХК	Газрын харилцаа, барилга геодези зураг зүйн газар	2014.02.10
15	Хувьсгалчдын гудамж, Зурагтын шинэ эцсээс Баянхошууны тойргийн уулзвар хүртэлх 4.6 км автозамын өргөтгөл, шинэчлэлтийн ажил	7 178.2	"Эйч Ай Би" ХХК	Барилгын Хөгжлийн төв	2013.06.03
16	Нарны замаас Саруул хотхон хүртэлх 0.24 км автозам, нүхэн гарц 55м гүүрийн ажил	1 771.2	"Мон-Аз" ХХК	Барилгын хөгжлийн төв	2014.05.23
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>90 332.1</b>			

Эх сурвалж: Нийслэлийн Авто замын хөгжлийн газар

Дээрх ажлуудаас 15 төсөл, арга хэмжээ нь баталгаажсан зураг, төсөвтэй, 1 ажил зураг төсөвгүй байна.

<sup>1</sup> Нийслэлийн Аудитын газрын жил бүрийн төлөвлөгөөт аудитуудаар дийлэнх ажил хамрагдсан тул эрсдэлийн үнэлгээг харгалзан 16 ажлыг түүвэрлэж үзсэн.

1.2. НАЗГ нь төсөвт тусгагдаагүй, зураг төсөвгүй 1 ажлыг гэрээ байгуулахгүйгээр гүйцэтгүүлсэн зөрчил илэрлээ. Тухайлбал:

ТЭЦ-3 баруун талын 0.33 км авто зам"-ын ажлыг нийслэлийн авто зам, тохижилтын үйл ажиллагааг хариуцан ажиллаж байсан Нийтлэг үйлчилгээний Улаанбаатар нэгтгэл /хуучин нэрээр/-ийн хөрөнгөөр гүйцэтгүүлсэн боловч өнөөг хүртэл гүйцэтгэгч байгууллага нь ажлын гүйцэтгэл болох 154.7 сая төгрөгийн санхүүжилтээ авч чадаагүй байна. Үүний шалтгаан нь энэ ажил анхнаасаа холбогдох хууль, журмыг зөрчсөн, мөн тухайн үеийн ажил хариуцаж байсан удирдлага солигдсон зэргээс болж санхүүжилтийн асуудал удааширсан байдалтай болжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4<sup>2</sup>, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1<sup>3</sup>, 46 дугаар зүйлийн 46.1.1<sup>4</sup>, 46.1.3<sup>5</sup>, 46.1.4<sup>6</sup>, 46.1.5<sup>7</sup>, Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2<sup>8</sup>-д заасныг тус тус зөрчжээ.

Иймд хууль, тогтоомжийг зөрчиж, зураг төсөвгүйгээр ажил гүйцэтгүүлэхээр шийдвэр гаргасан холбогдох албан тушаалтнуудыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй байна.

**Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын 15 ажил батлагдсан эх үүсвэр, зураг төсөвтэй, 1 ажил нь зураг төсөвгүйгээр хийгдсэн байна.**

<sup>2</sup> "Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана"

<sup>3</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө.

<sup>4</sup> энэ хуульд заасны дагуу үнэлгээний хороо байгуулах

<sup>5</sup> үнэлгээний хорооноос гаргасан дүгнэлтэд үндэслэн гэрээ байгуулах эрх олгох шийдвэр гаргах

<sup>6</sup> худалдан авах бараа, ажил, үйлчилгээг батлагдсан төсөвт багтаан үр ашигтай төлөвлөж, зохион байгуулах

<sup>7</sup> тухайн бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх

<sup>8</sup> Барилгын ажлыг зураг төсөлгүйгээр гүйцэтгэхийг хориглоно.

## ХОЁР. Сонгон шалгаруулалтыг хууль журмын дагуу явуулсан эсэх

2.1. НЗД-ын 2013 оны А/135, 2014 оны А/07-01, А/07-02, А/519-02, А/662-9, 2015 оны А/42, А/267, 2016 оны А/68, А/180, А/293 дугаар захирамжуудаар улс, нийслэл, замын сангийн хөрөнгөөр хийх хөрөнгө оруулалтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах 9 үнэлгээний хороог байгуулжээ.

Аудитад хамрагдсан авто зам, замын байгууламжийн худалдан авах ажиллагаанд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1<sup>9</sup>, Концессын тухай хуулийн 11 дүгээр зүйл<sup>10</sup>, Засгийн газрын 2012 оны 103<sup>11</sup> дугаар тогтоолыг мөрдөж, 81 460.0 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээнд нээлттэй тендер болон концессын сонгон шалгаруулалт, 8 872.1 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээнд гэрээ шууд байгуулах аргыг хэрэглэжээ.

Худалдан авах ажиллагаа явуулсан төслийн нэр, ажиллагааны аргыг хүснэгт №2-оор үзүүлбэл:

Төсөл, арга хэмжээний нэр		ХАА-нд мөрдөгдсөн журам
1	СХД, Гүнтийн давааны автозамыг үргэлжлүүлэн 7,36 км автозам	концессын сонгон шалгаруулалт
2	Өвөр Гүнтийн 11 км авто зам	концессын сонгон шалгаруулалт
3	Нисэхийн товчоо-Биокомбинат-Шувуун фабрик чиглэлийн 22.5 км авто замын өргөтгөл /ХУД/	Нээлттэй тендер шалгаруулалт
4	Төмөр замын урдуурх хэвтээ тэнхлэгийн гол гудамж замын зүүн хэсгийн үргэлжлэл 6.0 км авто зам /Дүнжингарав худалдааны төвийн замаас Улиастайн замын уулзвар хүрэх/ /БЗД/	Нээлттэй тендер шалгаруулалт
5	Гандийн гудамжны 1,6 км авто замын засвар, шинэчлэлтийн ажил Багц-1 /урд талын зам км 0.00- км 760, хойд тал км 0.00-км 684,57/	Гэрээ шууд байгуулах арга
6	Гэндэнгийн гудамжны авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажил /0.6 км/	Гэрээ шууд байгуулах арга
7	"Яармагаас Жаргалант орох 3,4 км автозам, 400 автомашины зогсоол"-ын барилгын ажил	Гэрээ шууд байгуулах арга
8	Замын хөдөлгөөний зөрчил илрүүлэх болон авто замын хяналтын телекамер суурилуулах	Гэрээ шууд байгуулах арга
9	Богд уулын арын авто замын гэрэлтүүлэг Багц 2	Гэрээ шууд байгуулах арга
10	ТЭЦ-3 баруун талын 0,33 км автозам, СХД 1 дүгээр хорооллын арын авто замын үйлдвэрчний гудамжтай холбох 0,89 км авто зам, Өгөөмөр захын хойд талын 0,5 км авто зам	гэрээ байгуулаагүй
11	Нарны замыг 19-р хорооллын арын замтай холбох 1,5 км шинэ зам, замын байгууламжийн 58 у/м гүүр болон төмөр замын доогуурх Нарны замтай холбогдсон 22м туннелийн хамт	Нээлттэй тендер шалгаруулалт
12	Баатархайрханаас Гахайн хороо орох замыг засах /БЗД, 23-р хороо/	Нээлттэй тендер шалгаруулалт
13	Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо Яргайтын богины ам	концессын сонгон шалгаруулалт
14	Налайх дүүрэг, Петровисын ШТС-аас Цайз захын замын уулзвар хүртэлх 1,3 км авто зам	Нээлттэй тендер шалгаруулалт
15	Хувьсгалчдын гудамж Зурагтын шинэ эцсээс Баянхошууны тойруугийн уулзвар хүртэлх 4.6 км авто замын өргөтгөл, шинэчлэлт	Нээлттэй тендер шалгаруулалт
16	Нарны замаас Саруул хотхоны авто зам хүртэлх 0,24 км авто зам, нүхэн гарц, 55 у/м гүүр	Нээлттэй тендер шалгаруулалт

Эх сурвалж: Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар

2.2. ТБОНӨХБАҮХАТХ-ийн 28 дугаар зүйлийн 28.11<sup>12</sup>-д зааснаар «хамгийн сайн» гэж үнэлэгдэж, шалгарсан оролцогчийн тендерийн баримт материалыг шалгахад 4 үнэлгээний хорооны үйл ажиллагаанд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

9 985.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгч байгууллагыг сонгохдоо санхүү, ижил төстэй ажил болон туршлагын талаарх мэдээллийг бүрэн магадлаж үнэлээгүй нь уг

<sup>9</sup> 3.1-д "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авахад энэ хуулийг дагаж мөрдөнө",

<sup>10</sup> "Төсөл сонгон шалгаруулах уралдаант шалгаруулалт явуулах"

<sup>11</sup> Уралдаант шалгаруулалтын нарийвчилсан журам, жишиг баримт бичиг, санал үнэлэх журам батлах тухай

<sup>12</sup> 28.11. Захиалагч шаардлагад нийцсэн тендерүүдийг үнэлж «хамгийн сайн» үнэлэгдсэн тендерийг шалгаруулахад шалгуур үзүүлэлтүүдийг тендерийн баримт бичигт заасан журмын дагуу ашиглана.



хуулийн 12 дугаар зүйлийн 12.1<sup>13</sup>, 15-16<sup>14</sup> дугаар зүйлд заасныг зөрчсөн, 4 359.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлын үнэлгээний хороонд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшээгүй гишүүнийг оролцуулсан нь мөн хуулийн 47 дугаар зүйлийн 47.6<sup>15</sup>, СС-ын 2014 оны 212 дугаар тушаалаар батлагдсан журмын 2.2-д<sup>16</sup> заасныг тус тус зөрчжээ. Тухайлбал:

- Налайх дүүрэг, Петровис ШТС-ын уулзвараас Цайз зах хүртэлх 1.3 км автозамын ажилд шалгарсан “Оч Наран” ХХК-ийн ерөнхий инженер, хөдөлмөр хамгааллын инженер нь тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн 5.3/г/-д заасан 3 жил ажилласан байх шаардлагыг хангаагүй;

- Хувьсгалчдын гудамж, Зурагтын шинэ эцсээс Баянхошууны тойргийн уулзвар хүртэлх 4.6 км автозамын өргөтгөл, шинэчлэлтийн ажилд шалгарсан “Экспресс зам” ХХК-ийн ерөнхий инженер, замын инженер, хэмжилтийн инженер, материалын инженер, механикийн инженер, хөдөлмөр хамгааллын инженер нь тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн 5.3/г/-д заасан 3-5 жил тухайн мэргэжлээрээ ажилласан байх шаардлагыг хангаагүй;

- Нарны замыг 19 дүгээр хорооллын арын замтай холбох 1.5 км авто зам, замын байгууламжийн 58 у.м, Төмөр зам доогуурх Нарны замтай холбогдсон 22 м тунелийн хамт барих ажлын тендер шалгаруулах үнэлгээний хорооны 1 гишүүн нь АЗ гэрчилгээгүй.

- Нарны замаас Саруул хотхон хүртэлх 0.24 км автозам, нүхэн гарц 55м гүүрийн ажилд шалгарсан “Мотор Сервис” ХХК-ийн материалд тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгтийн 5.3/д/-д заасан түргэн хөрвөх чадварын мэдээлэл дутуу;

Үнэлгээний хороонд худалдан авах чиглэлээр мэргэшээгүй гишүүнийг ажиллуулж, санхүү, техникийн чадавхи болон ажлын туршлагыг харгалзаж үзээгүй нь тендерийг буруу үнэлэх, туршлагагүй гүйцэтгэгч шалгарах нөхцлийг бүрдүүлж, НХААГ-ын холбогдох албан тушаалтнууд ажилдаа хариуцлагагүй хандсан байна.

**НХААГ нь сонгон шалгаруулалтыг явуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчжээ.**

<sup>13</sup> Тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдүүдийн ерөнхий, санхүүгийн, техникийн чадавхи болон туршлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр хянан үзэж магадлана.

<sup>14</sup> 15 дугаар зүйл. Санхүүгийн чадавхийг үнэлэх, 16 дугаар зүйл. Техникийн чадавхи болон туршлагыг үнэлэх

<sup>15</sup> 47.6. Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байна.

<sup>16</sup> Үнэлгээний хорооны гишүүд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн байх.

**ГУРАВ. Төсөл, арга хэмжээний үе шат бүрт захиалагчийн хяналт болон дотоод хяналтыг хууль, журмын дагуу явуулсан эсэх**

Улаанбаатар хотод төсвийн хөрөнгөөр хэрэгжсэн авто замын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд НАЗГ-аас захиалагчийн хяналтыг хэрэгжүүлжээ.

3.1. Аудитаар СХД, Гүнтийн давааны авто замыг үргэлжлүүлэн 7.36 км авто зам, Өвөр Гүнтийн 11 км авто зам, Нисэхийн товчоо-Био комбинат Шувуун фабрикийн чиглэлийн 22.5 км авто замын ажил, Төмөр замын урдуурх хэвтээ тэнхлэгийн гол гудамж замын зүүн хэсгийн үргэлжлэл 6,0 км авто зам /Дүнжингарав худалдааны төвийн замаас Улиастайн уулзвар хүрэх/-ын ажлын нийт 65 210.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний зураг төсөв, гүйцэтгэлийн материалуудыг мэргэжлийн шинжээч, итгэмжлэгдсэн лабораторийн багтай хамтран шалгахад төсөвт магадлал хийлгээгүй дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зөрчлийг хураангуйлан хүснэгт №3-аар үзүүлбэл:

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Батлагдсан төсөвт өртөг /тэрбум/	Гүйцэтгэгч компани	Үүнээс илэрсэн зөрчлийн	
				Үнийн дүнгийн зөрүү /сая.төг/	утга
а	Төмөр замын урдуурх хэвтээ тэнхлэгийн гол гудамж замын зүүн хэсгийн үргэлжлэл 6,0 км авто зам	10 901.8	“Хансуун зам” ХХК	403.0	Гэрэлтүүлгийн ажлын зураг төсөл 1 336.6 сая төгрөг боловч 1 739.3 сая төгрөг болгон нэмэгдүүлж, магадлал хийлгээгүй.
				374.0	“Төмөр замын 413-р км дэх 14м өргөн бүрэн автомат ажиллагаатай гарам” барих ажилд 398.8 сая төгрөгийн гэрээтэй боловч гүйцэтгэлээр 772.4 сая төгрөг болж, магадлал хийлгээгүй.
б	СХД, 21 дүгээр хороо, Өвөр гүнтийн 11,6 авто замын барилгын ажил	13 333.7	“Арц суврага” ХХК	2 579.0	2013 онд 10 754.7 сая төгрөгөөр хянаж батласан боловч 2016 онд зураг төслийг магадлалаар оруулалгүйгээр 13 333.7 сая төгрөгөөр гэрээг байгуулсан.
в	ЧД, Гүнтийн давааны авто замыг үргэлжлүүлэх 7.36 км авто замын барилгын ажил	10 896.6	“Билэгт зам” ХХК	6 023.8	2011 онд 4 872.8 сая төгрөгөөр батлагдаж, магадлалын ерөнхий дүгнэлт хийгдсэн боловч 2016 онд зураг, төсвийг магадлалаар оруулалгүй 10 896.6 сая төгрөгөөр гэрээг байгуулжээ.
	<b>ДҮН</b>	<b>35 132.1</b>		<b>9 379.8</b>	

**“Хансуун зам” ХХК:**

- Гэрэлтүүлгийн ажлын анхны зураг төсөл 1 336.6 сая төгрөгийн экспертизээр батлагдсан , 1 739.3 сая төгрөг болгож ажлын зураг төсвийг өөрчилсөн боловч түүнд магадлал хийлгээгүй;
- “Төмөр замын 413-р км дэх 14м өргөн бүрэн автомат ажиллагаатай гарам” барих ажилд 398.8 сая төгрөгийн гэрээтэй, 772.4 сая төгрөгийн гүйцэтгэл гарч санхүүжүүлсэн боловч илүү гүйцэтгэсэн ажлын төсөвт магадлал хийлгүүлээгүй;
- Замын зорчих хэсэгт чанарын баталгааны хугацаа дуусахаас өмнө хагарал, гэмтэл гарсан байна.



**“Арц суврага” ХХК:**

- Анхны зураг төсөл 2012 онд батлагдаж, 2013 онд 10 754.7 сая төгрөгөөр магадлалын ерөнхий дүгнэлтээр хянасан боловч 2016 онд зураг төслийг шинэчилж, магадлалаар оруулалгүйгээр 13 333.7 сая төгрөгөөр зам барих гэрээг байгуулсан байна.

**“Билэгт зам” ХХК:**

- Чингэлтэй дүүрэг Гүнтийн давааны авто замыг үргэлжлүүлэх 7.36 км авто замын барилгын ажил анх 2011 онд 4 872.8 сая төгрөгөөр батлагдаж, магадлалын ерөнхий дүгнэлт хийгдсэн боловч 2016 онд зураг, төсвийг магадлалаар оруулалгүй 10 896.6 сая төгрөгөөр гэрээг байгуулжээ.

Дээрх зөрчлүүд нь Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4<sup>17</sup>, ЗГ-ын 2009 оны 204 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх” дүрмийн 7.1<sup>18</sup> -д заасныг тус тус зөрчжээ.

3.2. Итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнг замын зурагт багтсан техникийн шаардлагыг тодорхойлсон үзүүлэлттэй харьцуулахад СХД, Гүнтийн давааны авто замыг үргэлжлүүлэн 7.36 км авто зам, Төмөр замын урдуурх хэвтээ тэнхлэгийн гол гудамж замын зүүн хэсгийн үргэлжлэл 6.0 км авто зам гэсэн 2 ажлын 14 хэсэгт нь сорьц авснаас 4 хэсэгт нь асфальт зузааны хэмжээ ажлын зураг, төсөвт заагдсан хэмжээнээс 2.2-1.5 см-ээр бага байна.

Шинжилгээний дүнгийн мэдээллийг хүснэгт №4-өөр үзүүлбэл:

Ажлын зураг болон лабораторийн шинжилгээний дүн				
№	Батлагдсан төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Ажлын анхны зурагт тусгагдсан асфальтны хэмжээ /см/	Лабораторийн шинжилгээгээр гарсан асфальтны хэмжээ /см/	Дээж авсан хугацаа
1	СХД, Гүнтийн давааны авто замыг үргэлжлүүлэн 7.36 км авто зам	7.0	5.5-9.4	2017.04.20
2	Өвөр Гүнтийн 11 км авто зам	7.0	8.0-10.5	2017.04.20
3	Нисэхийн товчоо-Био комбинат Шувуун фабрикийн чиглэлийн 22,5 км авто замын ажил	7.0	7.7-12.8	2017.04.17
4	Төмөр замын урдуурх хэвтээ тэнхлэгийн гол гудамж замын зүүн хэсгийн үргэлжлэл 6,0 км авто зам /Дүнжингарав худалдааны төвийн замаас Улиастайн уулзвар хүрэх/-ын ажил	7.0	4.8-7.9	2017.04.17

Дээрх ажлуудын зураг төсөвт орсон өөрчлөлтүүдэд магадлал хийлгээгүй, хяналтын төсөв, гэрээний дүнгээс ажлын гүйцэтгэл зөрүүтэй, нотлох баримт дутуу, захиалагч тооцооллыг бүрэн хийгээгүй, үе шатны зарим ил далд ажлын акт, зурагаар баталгаажуулах, тэмдэглэл үйлдэх зэрэг баримт, материалын бүрдүүлэлт хангалтгүй байгаа нь Засгийн газрын 2009 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан Барилга захиалагчийн дүрмийн 3.1.2<sup>19</sup>, 3.1.7<sup>20</sup>-д заасныг зөрчиж, НАЗГ /хуучин нэрээр/-ын тухайн үеийн удирдлагууд ажилдаа хариуцлагагүй хандсан байна.

Иймд мэргэжлийн шинжээчийн багт НАЗХГ /шинэ нэрээр/-аас гаргаж өгсөн холбогдох баримт, материалуудын хүрээнд дээрх зөрчлүүд илэрч байгаа тул хууль, хяналтын байгууллагад шилжүүлэн шалгуулах нь зүйтэй байна.

Мөн зөрчилтэй асуудалтай дээрх авто замуудын ажлыг улсын комисс<sup>21</sup> хүлээн авсан нь Барилгын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.5<sup>22</sup>, 48.6<sup>23</sup>, Засгийн газрын 2012 оны 151 дүгээр

<sup>17</sup> Энэ хуулийн 25.2, 25.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгээгүй бол барилгын ажлын зөвшөөрөл олгохыг хориглоно.

<sup>18</sup> Барилгын тухай хуулийн 13.2, 13.3-т заасан барилгын зураг төсөлд магадлал хийнэ.

<sup>19</sup> 3.1.2. барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл, барилгын ил далд ажлын болон тоног төхөөрөмжийн туршилт, тохируулга хийсэн акт, холбогдох бусад баримт бичгийг гүйцэтгэгчээс гаргуулан авах, түүнийг баталгаажуулах;

<sup>20</sup> 3.1.7. барилгын ажлын үе шат бүрт зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэх;

<sup>21</sup> 2015-2016 онд 9-12 хүний бүрэлдэхүүнтэй.

<sup>22</sup> 48.5.Захиалагч энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллагад барилга байгууламжийг ашиглалтад оруулахаар хүсэлт гаргах бөгөөд түүнд дараахь баримт бичгийг хавсаргана:

48.5.1.барилгын үе шатны ажлын гүйцэтгэлийн тэмдэглэл;

48.5.2.барилгын ажлын ил, далд ажлын акт;

48.5.4.захиалагчийн барилгын техникийн хяналтын нээгдсэн дүгнэлт;

48.5.6.барилга байгууламжийн өөрчлөлтийн зураг төсөл;

<sup>23</sup> 48.6.Энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүсэлт, энэ хуулийн 48.5-д заасан баримт бичгийг хянаж, ажлын 10 өдрийн дотор ашиглалтад оруулах комисс ажиллуулна.

тогтоолоор баталсан “Барилгын ажлыг эхлүүлэх үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.12.1<sup>24</sup>, 4.12.7<sup>25</sup>-д заасныг зөрчжээ.

**НАЗГ нь захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс Барилгын тухай хууль болон Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрмийн холбогдох заалтыг тус тус зөрчжээ.**

#### ДӨРӨВ. Санхүүжилтийг хууль, журмын дагуу олгосон эсэх

4.1. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2012-2016 онд хэрэгжсэн нийт авто зам, замын байгууламжийн ажлуудын гэрээний дүн, гүйцэтгэлийн болон санхүүжилтийн мэдээ, замын урт, талбайн хэмжээ зэрэг мэдээ тайланг нэгтгэсэн судалгааг НАЗХГ гаргаж өгөөгүйгээс аудитын явцад шалгагдсан 16 ажлаас бусад төсөл, арга хэмжээнд дүн шинжилгээ хийх боломжийг хязгаарласан болно.

Аудитад хамрагдсан 90.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 16 төсөл, арга хэмжээний 88.3 тэрбум төгрөгийн гэрээний санхүүжилтийг тулгахад 13 төсөл, арга хэмжээнд Хөгжлийн банкнаас 1.3 тэрбум, улсын төсвөөс 30.5 тэрбум, нийслэлийн төсвөөс 29.8 тэрбум, нийт 61.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлээр гэрээний дагуу олгосон, гэрээний дагуу ажил дуусч, улсын комисс хүлээж авсан 5 төсөл, арга хэмжээний 26.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.

Ажил бүрэн дууссан боловч олгогдоогүй үлдэгдэл санхүүжилтийг хүснэгт №5-аар үзүүлбэл:

№	Батлагдсан төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эх үүсвэр	Нэр	Санхүүжих дүн	Олгогдоогүй санхүүжилт	Олгоогүй санхүүжилтийн хувь	Ажлын гүйцэтгэл	Улсын комисс хүлээн авсан	
								Актын дугаар	Актын огноо
1	СХД, Гүнтийн давааны авто замыг үргэлжлэл 7.36 км авто зам	Концесс	"Билэгт зам" ХХК	10848.8	10678.0	98.4	100%	2016/469	2016.11.02
2	Өвөр Гүнтийн 11 км авто зам	Концесс	"Арц Суврага" ХХК	13333.7	13333.7	100.0	100%	2016/568	2016.12.06
3	Гандийн гудамжны авто зам. Багц-1	Монгол улсын Хөгжлийн банк	"Хомын тал" ХХК	1060.9	489.0	46.1	100%	2016/331	2016.8.19
4	Гандийн гудамжны авто зам. Багц-2	Монгол улсын Хөгжлийн банк	"Үйлсийн зам" ХХК	1254.4	534.0	42.6	100%	2016/323	2016.8.10
5	Яармагаас Жаргалантын ам орох 3,4 км авто зам, 400 автомашины зогсоол"-ын барилгын ажил	Концесс	"Наранбулаг-Хан" ХХК	1762.0	1762.0	100.0	100%	2016/353	2016.9.15
	<b>Дүн</b>			<b>28 259.7</b>	<b>26796.7</b>				

Эх сурвалж: Нийслэлийн Авто замын хөгжлийн газар

**Ажлын гүйцэтгэл дууссан 6 ажлын 26.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.**

<sup>24</sup> ЗГ-ын 2012 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 181 дүгээр тогтоолоор баталсан “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм”-ийн 4.12.1-д “ комисс нь Барилгын тухай хууль, барилгын норм, нормативын бичиг, баримтад заасан шаардлагыг хангасан барилга байгууламжийг ашиглалтад оруулах үүрэг хүлээнэ,

<sup>25</sup> Дээрх дүрмийн 4.12.7-д “комиссын гишүүд мэргэжлийнхээ чиглэлээр илэрсэн зөрчил дутагдлыг бүрэн арилгуулсны дараа энэхүү дүрмийн 2 дугаар хавсралтад заасан актад гарын үсэг зурж баталгаажуулна. Зөрчил дутагдлыг 14 хоногт бүрэн арилгасан байна

## ТАВ. Хөрөнгө оруулалтаар бий болсон ажлыг данс бүртгэлд тусгасан эсэх

5.1. Аудитад хамрагдсан төсөл арга хэмжээний 57.3 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 7 авто замын ажлыг 2013-2015 онд улсын комисс хүлээн авч, НАЗГ-ын бүртгэлд тусгажээ.

5.2. Улс болон нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2016 онд хэрэгжсэн 33.0 тэрбум төгрөгийн гэрээний үнийн дүнтэй 9 ажлаас 31.3 тэрбум төгрөгийн 7 ажлыг НАЗХГ нь нийслэлийн өмчид бүртгүүлэхээр 2017 оны 2 дугаар сарын 9-ний 4/188 дугаар албан бичгээр НӨХГ-т хүргүүлсэн байхад өмчийн бүртгэл хийгдээгүй нь Авто замын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1<sup>26</sup>, 14.2.4<sup>27</sup>, 14.2.5<sup>28</sup>, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2<sup>29</sup>-д заасан заалтуудыг хэрэгжүүлээгүйгээс төсвийн хөрөнгийн ашиглалт, хамгаалалт алдагдах, хөрөнгө оруулалтын үр дүн буурах эрсдлийг үүсгэжээ.

Нийт хэрэгжсэн авто зам, замын байгууламжийн ажлыг өмчийн бүртгэлд тусгасан байдлыг хүснэгт №6-аар үзүүлбэл:

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Өмчийн бүртгэлд хамрагдсан эсэх
1	СХД, Гүнтийн давааны автозамыг үргэлжлүүлэн 7,36 км автозам	үгүй
2	Өвөр Гүнтийн 11 км авто зам	үгүй
3	Нисэхийн товчоо-Биокомбинат-Шувуун фабрик чиглэлийн 22.5 км авто замын өргөтгөл /ХУД/	тийм
4	Төмөр замын урдуурх хэвтээ тэнхлэгийн гол гудамж замын зүүн хэсгийн үргэлжлэл 6.0 км авто зам /Дүнжингарав худалдааны төвийн замаас Улиастайн замын уулзвар хүрэх/ /БЗД/	тийм
5	Гандийн гудамжны 1,6 км авто замын засвар, шинэчлэлтийн ажил Багц-1 /урд талын зам км 0.00- км 760, хойд тал км 0.00-км 684,57/	үгүй
6	Гэндэнгийн гудамжны авто замын өргөтгөл, шинэчлэлтийн ажил /0.6 км/	тийм
7	"Яармагаас Жаргалант орох 3,4 км автозам, 400 автомашины зогсоол"-ын барилгын ажил	үгүй
8	Замын хөдөлгөөний зөрчил илрүүлэх болон авто замын хяналтын телекамер суурилуулах	үгүй
9	Богд уулын арын авто замын гэрэлтүүлэг Багц 2	үгүй
10	ТЭЦ-3 баруун талын 0,33 км автозам, СХД 1 дүгээр хорооллын арын авто замын үйлдвэрчний гудамжтай холбох 0,89 км авто зам, Өгөөмөр захын хойд талын 0,5 км авто зам	шүүхийн маргаантай ажил
11	Нарны замыг 19-р хорооллын арын замтай холбох 1,5 км шинэ зам, замын байгууламжийн 58 у/м гүүр болон төмөр замын доогуурх Нарны замтай холбогдсон 22м туннелийн хамт	тийм
12	Баатархайрханаас Гахайн хороо орох замыг засах /БЗД, 23-р хороо/	үгүй
13	Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо Яргайтын богины ам	ажил хийгдээгүй
14	Налайх дүүрэг, Петровисын ШТС-аас Цайз захын замын уулзвар хүртэлх 1,3 км авто зам	тийм
15	Хувьсгалчдын гудамж Зурагтын шинэ эцсээс Баянхошууны тойруугийн уулзвар хүртэлх 4.6 км авто замын өргөтгөл, шинэчлэлт	тийм
16	Нарны замаас Саруул хотхоны авто зам хүртэлх 0,24 км авто зам, нүхэн гарц, 55 у/м гүүр	тийм

Эх сурвалж: Нийслэлийн Авто замын хөгжлийн газар

**2016 оны байдлаар хэрэгжиж дууссан зам, замын байгууламжийн ажлыг бүртгэлд бүрэн тусгаагүй нь Авто замын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтыг тус тус зөрчжээ.**

<sup>26</sup> ". . . орон нутгийн чанартай авто зам, замын байгууламжийн эзэмшигч нь аймаг, нийслэлийн Засаг дарга байна."

<sup>27</sup> авто зам, замын байгууламжийг ашиглалтад хүлээн авч тайлан бүртгэлдээ тусган арчлан хамгаалагчийг тогтоох;

<sup>28</sup> авто зам, замын байгууламжийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, баяжуулах;

<sup>29</sup> Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна. Төсөвт авсан зээл, хандив, дэмжлэг, тусламжаар бий болсон хөрөнгө үүнд нэгэн адил хамаарна.

## ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын 15 ажил нь батлагдсан эх үүсвэр, зураг төсөвтэй, 1 ажил нь зураг төсөвгүйгээр хийгдсэн байна.
2. НХААГ нь сонгон шалгаруулалтыг явуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтыг зөрчжээ.
3. НАЗГ нь захиалагчийн хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс Барилгын тухай хууль болон Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх дүрмийн холбогдох заалтыг тус тус зөрчжээ.
4. Ажлын гүйцэтгэл дууссан 6 ажлын 26.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдоогүй байна.
5. 2016 оны байдлаар хэрэгжиж дууссан зам, замын байгууламжийн ажлыг бүртгэлд бүрэн тусгаагүй нь Авто замын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн холбогдох заалтыг тус тус зөрчжээ.
6. Дараах ажлуудыг холбогдох хууль, тогтоомжийг зөрчиж гүйцэтгүүлсэн байна. Үүнд:

а. “ТЭЦ-3 баруун талын 0.33 км авто зам”-ын ажлыг зураг төсөвгүй, гэрээ байгуулалгүй хийлгүүлснээс ажлын гүйцэтгэл болох 154.7 сая төгрөгийн санхүүжилт шийдэгдээгүй. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, ТБОНӨХБАҮХАТХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1, 46 дугаар зүйлийн 46.1.1, 46.1.3, 46.1.4, 46.1.5, Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2-д заасныг тус тус зөрчсөн.

б. Мөн дараах ажлуудыг гүйцэтгүүлэхдээ Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4, ЗГ-ын 2009 оны 204 дугаар тогтоолоор батлагдсан “Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, зөвшилцөх, магадлал хийх” дүрмийн 7.1 -д заасныг тус тус зөрчжээ. Үүнд:

- Төмөр замын урдуурх хэвтээ тэнхлэгийн гол гудамж замын зүүн хэсгийн үргэлжлэл 6,0 км авто зам /Дүнжингарав худалдааны төвийн замаас Улиастайн уулзвар хүрэх/-ын ажлын “Гэрэлтүүлгийн ажлын зураг төсөл 1 336.6 сая төгрөг боловч 1 739.3 сая төгрөг болгон нэмэгдүүлсэн, “Төмөр замын 413-р км дэх 14м өргөн бүрэн автомат ажиллагаатай гарам” барих ажилд 398.8 сая төгрөгийн гэрээтэй боловч гүйцэтгэлээр 772.4 сая төгрөг болж, магадлал хийлгээгүй.

- СХД, 21 дүгээр хороо, Өвөр гүнтийн 11,6 авто замын барилгын ажил 2013 онд 10 754.7 сая төгрөгөөр хянаж батласан боловч 2016 онд зураг төслийг магадлалаар оруулалгүйгээр 13 333.7 сая төгрөгөөр гэрээг байгуулсан.

- ЧД, Гүнтийн давааны авто замыг үргэлжлүүлэх 7.36 км авто замын барилгын ажил 2011 онд 4 872.8 сая төгрөгөөр батлагдаж, магадлалын ерөнхий дүгнэлт хийгдсэн боловч 2016 онд зураг, төсвийг магадлалаар оруулалгүй 10 896.6 сая төгрөгөөр гэрээг байгуулжээ.

## ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдагдсан албан тушаалтанд зөвлөж байна.

### **Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид:**

1. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх үүднээс харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулж, мэргэжлийн алдаа гаргасан холбогдох албан тушаалтнуудад хариуцлага тооцох;
2. Цаашид дээрх зөрчлүүдийг дахин гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах.

### **Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргад:**

1. Сонгон шалгаруулалтыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй, мэргэжлийн алдаа гаргасан холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох;
2. Цаашид дээрх зөрчлүүдийг дахин гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллах.

### **Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын даргад:**

1. Нийслэлийн авто зам, замын байгууламжуудын талаар мэдээллийн нэгдсэн баазтай болох;
2. Захиалагчийн хяналтыг хэрэгжүүлээгүй, мэргэжлийн алдаа гаргасан албан тушаалтанд хариуцлага тооцох;
3. Цаашид дээрх зөрчлүүдийг дахин гаргахгүй байх талаар холбогдох арга хэмжээ авч, захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ хууль тогтоомжийг чанд мөрдөж ажиллах.

### **Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргад:**

1. Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон авто зам, замын байгууламжийг хөрөнгийн бүртгэлд бүрэн тусгаж, ашиглалт хамгаалалтыг сайжруулах.

Холбогдох байгууллагын санал



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
АВТО ЗАМЫН ХӨГЖЛИЙН ГАЗАР**

15180 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо,  
Бага тойруу-3, Ц.Жигжиджавын гудамж-9  
Нийслэлийн засаг захиргааны II байр, Хангарди ордон  
Утас: 32-53-85, Факс: (976-11) 32-44-98  
<http://www.road.ub.gov.mn>; [Info@road.ub.gov.mn](mailto:Info@road.ub.gov.mn)

2017.05.10 № 3/698  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

┌ МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ  
АУДИТЫН ГАЗАР ┐

Үндэсний аудитын газраас "Нийслэлд хэрэгжсэн зарим төсөл, хөтөлбөрийн хөрөнгийн зарцуулалт, хууль тогтоомжийн хэрэгжилт"-д хийсэн нийцлийн аудитын тайлантай танилцлаа.

"Төмөр замын 413-р км дэх 14м өргөн бүрэн автомат ажиллагаатай гарам" барих ажлын төсөв, гүйцэтгэлд хийсэн шинжээчийн дүгнэлтийг холбогдох нотлох баримт материалыг бүрэн судалж тодруулах шаардлагатай гэж үзэж байна.

Бусад дүгнэлт, зөвлөмжийн хувьд тусгайлсан саналгүй болно.

ДАРГА  Ж.ТОГТОХБАЯР



УХА0592 9115064  
1116 127918

1150500894